



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сайншанд сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/71/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дорноговь аймаг 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий	
	Утас: 70522734	Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn
	Аудитын менежер:	У.Оюунтүлхүүр
	Утас: 70523020	Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
	Ахлах аудитор:	Э.Энхцэцэг
Аудитор:		Цахим хаяг: enkhsetsege@audit.gov.mn
		Т.Мөнхтогтох
		Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2022.04.22 № 1-6/73

танай _____-ны № _____-т

САЙНШАНД СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Г.ТУНГАЛАГТУЯА ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сайншанд сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сайншанд сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.ГАН-ӨЛЗИЙ



Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	340.1	266.4
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	7,813.2	11,519.4
	Нийт хөрөнгийн дүн	8,153.3	11,785.8
	Нийт өр төлбөрийн дүн	-	94.3
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	8,153.3	11,691.5
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	8,153.3	11,785.8
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	3,474.6	6,149.4
	Үйл ажиллагааны зардлын дүн	2,306.3	2,610.6
	Үйл ажиллагааны үр дүн	1,168.3	3,538.8
	Үйл ажиллагааны бус үр дүн	113.1	0.6
	Үйл ажиллагааны нийт үр дүн	1,055.2	3,538.2
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,801.7	1,841.9
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,788.1	1,828.1
	Үйл ажиллагааны ЦМГ	13.6	13.8
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	13.6	13.8
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,098.1	8,153.3
	Тайлант оны үр дүн	1,055.2	3,538.2
	Эцсийн үлдэгдэл	8,153.3	11,691.5
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,174.9	1,020.8
	Урсгал зардал	1,174.9	1,020.8
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	1,174.9	1,020.8
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,174.7	1,020.7
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	0.2	0.1

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сайншанд сумын Засаг даргын Тамгын газрын эрхэм зорилго нь хүний хөгжлийг дээдэлсэн, амьдрах таатай орчин бүрдүүлсэн, байгаль орчинд ээлтэй аж үйлдвэрлэл, аялал жуулчлалаар тэргүүлэгч, эдийн засгийн өндөр чадвартай, хөгжлийн тулгуур хот болох гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагаагаа явуулж байна.

Байгууллагын 2021 онд дэвшүүлсэн зорилт:

- Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх;
- Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулинд дараах чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан байна. Үүнд:

- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги төлөвлөлт, хөтөлбөр, төслийг боловсруулах;
- Засаг даргын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцөлөөр хангах;
- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах;
- Хууль тогтоомж, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэрийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавьж үр дүнг тооцох;
- Засаг даргын Тамгын газрын бичиг хэргийг хөтлөх, байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;
- Төрийн захиргааны ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах;
- Тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хэвийн үйл ажиллагааг ханган үйлчлэх.

Гурав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 149 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй байна.

Дөрөв. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

Тав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 7 алдаа зөрчил илэрснээс, 2 албан шаардлага, 5 зөвлөмж өгсөн.

Албан шаардлага

1. Өмнөх аудитаар өгсөн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн бүртгэлтэй үндсэн хөрөнгийг шийдвэрлэх тухай зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүйд албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

2. Засгийн газрын 2021 оны А/43 дугаар "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын 1.1 батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаагүй, 1.6 Засгийн газрын шийдвэр гарснаас бусад тэмдэглэлт ойн зардалд Засаг даргын нөөц хөрөнгөөс 7.9 сая төгрөгийг зарцуулсанд албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Зөвлөмж

1. Тодруулгатай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант онд 92.8 сая төгрөгийн нийгмийн даатгалын өр үүсгэсэн, 2017 оноос хойш 6.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа тооцооны авлага өнөөг хүртэл тайланд тусгагдсан хэвээр байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа тооцооны авлага, өр төлбөрийг барагдуулах ажлыг зохион байгуулах.

2. Ажил гүйлгээний ангитай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Батлагдсан орлогын төлөвлөгөө 1,000,000 төгрөг, гүйцэтгэл 88,080 төгрөг, орлого 911,920 төгрөгөөр тасарсан байна

2.2. Өгсөн зөвлөмж:

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасантай нийцэхгүй байна.

Батлагдсан орлогын төлөвлөгөөг биелүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах.

3. Ажил гүйлгээний ангитай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Албан хэрэгцээнд ашиглаж буй 4 автомашинд Өмч хамгаалах зөвлөлөөр уг засвар үйлчилгээг зайлшгүй хийх шаардлагатай эсэх талаарх үндэслэлийг тогтоож, авч хэлэлцэж шийдвэрлээгүй 14.9 сая төгрөгийн засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгсэл худалдан авсан байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр “Жишиг норм батлах тухай” тушаалын 5 дугаар хавсралт “Автомашинны сэлбэг хэрэгслийн эдэлгээний доод хязгаар норм”-той нийцэхгүй байна.

Автомашинд сэлбэг хэрэгсэл худалдан авахдаа байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлөөрөө хэлэлцүүлэн шийдвэрлүүлж байх.

4. Дансны үлдэгдэлтэй холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 2 дугаар хуралдаанаар Сайншанд сумын Засаг даргын нөөц хөрөнгийг 20.0 сая төгрөгөөр баталсан байхад Сайншанд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/05 дугаар тогтоолоор 100.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 120.0 сая төгрөгөөр төсөв баталж, гүйцэтгэлээр 98.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

4.2. Өгсөн зөвлөмж:

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй, 6.2.2-т “жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх, 6.4.1. “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Төсвийн тухай хуульд заасан төсөв батлахтай холбоотой заалтуудыг хэрэгжүүлж ажиллах.

5. Ажил гүйлгээний ангитай холбоотой асуудал

5.1 Илрүүлэлт:

Цалинг холбогдох зааврын дагуу бүртгээгүй байна.

5.2 Өгсөн зөвлөмж:

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн “6.3.2 санхүүгийн аливаа үйл ажиллагааг НББОУС-ын дагуу цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэж тайлагнах”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 1 дүгээр хавсралтын 3.6 дахь заалттай нийцэхгүй байна.

Цалингийн бүртгэлийг холбогдох зааврын дагуу хийж байх.

6.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			

6.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	Сайншанд сумын ЗДТГ	7	-	-	-	-	-	2	-	5	-
	НИЙТ	7	-	-	-	-	-	2	-	5	-